



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/48

Дэлгэрхаан сум

**“Жишиг хашаатай өрх шалгаруулах аяны журам”
боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.5 дахь заалт, Сумын Засаг даргын үйл ажиллгааны мөрийн хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд орчны эрүүл мэнд, хөрсний бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах таатай нөхцөл бүрдүүлэн, Төр, иргэний хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлж, оролцоог дэмжих зорилгоор “Жишиг хашаатай өрх” шалгаруулах аяны журам, удирдамжийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Батнасан

(Засаг дагын орлогч)

Гишүүд:

Д.Урангоо

(Тамгын газрын дарга)

Н.Цэнддолжин

(2-р багийн Засаг дарга)

Б.Мөнхболд

(3-р багийн Засаг дарга)

Д.Оюунчимэг

(4-р багийн Засаг дарга)

Ч.Батзориг

(Газрын даамал)

Х.Мөнхбат

(Байгаль хамгаалагч)

Г.Батнасан

(5-р багийн Засаг дарга)

Ш.Цэрэндулам

(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

О.Батбаяр

(Эрүүл мэндийн төвийн эрхлэгч)

Н.Доржнамжил

(Соёлын төвийн дарга)

Э.Сумъяа

(Аварга тохижилт аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга)

Нарийн бичиг дарга: У.Ариунтуяа

(Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

2.“Жишиг хашаатай өрх” аяны удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Дээрх аяны хүрээнд идэвх санаачилгатай оролцож эгнээ хорооллоо эмхлэн цэгцэлж, хашааныхаа өнгө үзэмжийг сайжруулах, эвдрэл гэмтлийг засварлаж, шинэчлэж, зохион байгуулалттай тохижуулж ажиллах, иргэдэд сурталчилахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батнасан)-д даалгасугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

Засаг даргын 2025 оны 05 дүгээр сарын 30 ны
өдрийн 8/18 дугаар захирамжийн хавсралт

**ДЭЛГЭРХААН СУМЫН ТӨВИЙН АЙЛ ӨРХИЙН ДУНД
“ ЖИШИГ ХАШААТАЙ ӨРХ ” ШАЛГАРУУЛАХ
АЯНЫ УДИРДАМЖ**

Аварга

Зорилго: Сумын хэмжээнд орчны эрүүл мэнд, хөрсний бохирдлыг бууруулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах таатай нөхцөл бүрдүүлэн, төр, иргэний хоорондын хамтын ажиллагааны идэвхтэй оролцоог дэмжин, цаашид нутаг орны түүхт онцлогийг харуулсан аялал жуулчлалыг хөгжүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: Сумын төвийн айл өрх хамрагдана.

Хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 01 өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 25 өдөр хүртэл

Шалгаруулах үзүүлэлт:

1.Хог хаягдлын тухай хуулийн дагуу айл өрхүүд хог хаягдлаа стандартад нийцсэн савтай байх / Сав хийлгэсэн зардал болон, худалдаж авсан баримт /

- 1.1.Энгийн хог хаягдлыг эх үүсгэвэр дээр нь стандартын дагуу ангилан ялгасан байх
- 1.2.Тээвэрлэхэд амар хялбараар шийдвэрлсэн байх / ТҮК-ын тодорхойлолт /

2.Хөрсний эрүүл ахуй аюулгүй байдлыг хангах

- 2.1.Бохирын цооногтой байх
- 2.2.00-ыг хөрсөнд нэвчихгүй эко болгосон байх / хийх үеийг зураг /
- 2.3.Сумын хэмжээнд байгаль орчин бохирдуулсны татвар, энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйлчилгээний хураамжийг сар бүр төлсөн байх /татварын байцаагчийн тодорхойлолт /

3.Хашааны өнгө үзэмжийг сайжруулах

- 3.1. Нийтлэг хүрэн зосоор зосдсон байх
- 3.2. Гарнизыг нийтлэг цагаан өнгөөр будсан байх
- 3.3. Хашааны хээ хэт олон биш байх

4.Өнгө үзэмж нэмж байгаа үйл явцыг цахимд байршуулсан байх

5.Хашаандаа шинээр 5 доошгүй мод тарьж ургуулсан байх

6.Хашаандаа гэрэлтүүлэг шийдсэн байх

Ажил шалгаруулах бүрэлдэхүүн:

- Д.Батнасан - Засаг дагын орлогч
- Д.Урангоо - Тамгын Газрын дарга
- Н.Цэнддолжин - 2-р багийн Засаг дарга
- Б.Мөнхболд - 3-р багийн Засаг дарга
- Д.Оюунчимэг-4 –р багийн Засаг дарга
- Ч.Батзориг- Газрын даамал
- У.Ариунтуяа - БОХУ-ын байцаагч
- Х.Мөнхбат -Байгаль хамгаалагч
- Г.Батнасан - 5-р багийн Засаг дарга
- О.Батбаяр - Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
- Н.Доржнамжил- Соёлын төвийн дарга
- Э.Сумъяа - ОНӨТҮГ-ын дарга

Ж.Энхцэцэг- ИТХурлын байгаль орчин, хөдөө аж ахуйн

хорооны гишүүн

Шагналын сан:

1-р байр Өргөмжлөл 3,000,000

2-р байр Өргөмжлөл 2,500,000

3-р байр Өргөмжлөл 2,000,000


4-р байр Өргөмжлөл 1,500,000

5-р байр Өргөмжлөл 1,000,000



$\frac{20}{\text{بصره}}$ $\frac{20}{\text{بصره}}$ $\frac{20}{\text{بصره}}$

(بسم الله الرحمن الرحيم)



אשר...

1. ... אשר ... (אשר ...)

אשר ...

2. ... אשר ...

3. ... אשר ...

(אשר ...)

אשר ...

אשר ...

(אשר ...)

אשר ...

(אשר ...)

אשר ...